

ХасБанкны Төлөөлөгч удирдах зөвлөлийн 2023 оны  
7 дугаар сарын 07-ны өдрийн Р-2023-42 дугаар тогтоолын Хавсралт



## Мэдээллийг ил тод болгох ерөнхий журам

## ГАРЧИГ

### АГУУЛГА

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. ЗОХИЦУУЛАХ ХАРИЛЦАА .....	3
ХОЁРДУГААР ЗҮЙЛ. НЭР ТОМЬЁО.....	3
ГУРАВДУГААР ЗҮЙЛ. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙХ ЗАРЧИМ .....	3
ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. ХУГАЦААТ ТАЙЛАН, МЭДЭЭ .....	3
ТАВДУГААР ЗҮЙЛ. ТУХАЙ БҮР МЭДЭЭЛЭХ МЭДЭЭ.....	5
ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. БАНКНЫ ТАЛААР МЭДЭЭЛЭЛ АВАХ .....	6
ДОЛДУГААР ЗҮЙЛ. МЭДЭЭЛЛИЙГ НЭЭЛТТЭЙ БОЛГОХОД ТАВИГДАХ ХЯЗГААРЛАЛТ, ХОРИГЛОХ ЗҮЙЛ.....	7
НАЙМДУГААР ЗҮЙЛ. ХАРИУЦЛАГА.....	7

## НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. ЗОХИЦУУЛАХ ХАРИЛЦАА

- 1.1 Энэхүү журмаар ХасБанк (цаашид “Банк” гэх)-ны хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий байгууллагуудад Банкны талаарх мэдээллийг холбогдох хууль, журамд заасан хугацаа, хэлбэр, давтамжийн хүрээнд ил тод тайлагнан, мэдээлэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү журмыг Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон зохицуулагч байгууллагын холбогдох хэм хэмжээ тогтоосон эрх зүйн акт болон Банкны дүрэмд нийцүүлэн боловсруулсан болно.
- 1.3 Энэхүү журамд Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ буюу цаашид “Хороо” гэх), Монголбанк, Монголын Хөрөнгийн Бирж (МХБ буюу цаашид “Хөрөнгийн Бирж” гэх)-ийн холбогдох зохицуулалтад үндэслэн Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн хурлын шийдвэрээр нэмэлт өөрчлөлт оруулна.
- 1.4 Энэхүү журмын хэрэгжилтэд Банкны ТУЗ хяналт тавина.

## ХОЁРДУГААР ЗҮЙЛ. НЭР ТОМЬЁО

- 2.1. Энэхүү журамд хэрэглэгдсэн дараах нэр томьёо, тэдгээрийн тайлбарыг нэг утгаар ойлгож, хэрэглэнэ:
  - 2.1.1 “Дотоод мэдээлэл эзэмшигч” гэж “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 77.1 болон Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам”-ын дагуу тодорхойлсон этгээдийг;
  - 2.1.2 “Мэдээллийг нээлттэй болгох” гэж Банк нь холбогдох хууль тогтоомж болон энэхүү журмын дагуу мэдээллийг нээлттэй болгохдоо Банкны өөрийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудас, мөн Хорооноос шаардлагатай гэж үзсэн тохиолдолд бусад нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэхийг;
  - 2.1.3 “Хугацаат тайлан, мэдээ” гэж Банкнаас хувьцаа эзэмшигчийн хурал болон хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх зорилгоор өөрийн үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээллийг;
  - 2.1.4 “Тухай бүр мэдээлэх” гэж Банкны хувьцааны ханшид нөлөөлөх боломжтой, нөлөөлж болзошгүй аливаа мэдээллийг ердийн боломжит хугацаанд мэдээлэхийг;

## ГУРАВДУГААР ЗҮЙЛ. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙХ ЗАРЧИМ

- 3.1 Банк нь мэдээллийн ил тод байдал, тайлагналыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:
  - 3.1.1 Холбогдох хууль, журмын дагуу мэдээлвэл зохих тайлан, мэдээг зохих хэлбэр, давтамж, агуулгын хүрээнд цаг хугацаанд нь саадгүй мэдээлэх;
  - 3.1.2 Банкны бизнест материаллаг эерэг болон сөрөг нөлөө үзүүлж болохуйц аливаа үйл явдал, шийдвэрийн талаарх мэдээллийг тухай бүр Банкны шийдвэрт үндэслэн мэдээлэх;
  - 3.1.3 Банкны бүх хувьцаа эзэмшигчдийг ижил, тэнцвэртэй мэдээллээр хангах;
  - 3.1.4 Банкны бизнесийн нууц болон мэдээллийн ил тод байдлын тэнцвэртэй байдлыг хангах.

## ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. ХУГАЦААТ ТАЙЛАН, МЭДЭЭ

- 4.1 Банк нь хугацаат тайлан, мэдээг олон нийтэд толилуулахдаа Хорооны “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай” журам, Хөрөнгийн Биржийн “Үнэт цаас гаргагчийн цахим тайлан ирүүлэх” зааврыг тус тус мөрдөнө.

- 4.2 Хугацаат тайлан, мэдээнд санхүүгийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, хагас жил болон улирлын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан тус тус хамаарна.
- 4.3 Санхүүгийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө олон нийтэд мэдээлэх бөгөөд дараах хэлбэр, агуулгатай байна. Үүнд:
- 4.3.1 Тайлант хугацааны санхүүгийн мэдээлэл болон дүн шинжилгээ;
  - 4.3.2 Хөндлөнгийн хараат бус аудитороор баталгаажуулсан санхүүгийн тайлан, түүний тодруулга, аудиторын дүгнэлт;
  - 4.3.3 Санхүүгийн жилд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаар мэдээлэл;
  - 4.3.4 Хөрвөх чадвар болон шинээр татсан гадаад эх үүсвэр, түүний удирдлагын талаар мэдээлэл;
  - 4.3.5 Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлт;
  - 4.3.6 Бизнесийн гадаад, дотоод орчны нөхцөл байдлын талаар удирдлагын дүгнэлт, дүн шинжилгээ;
  - 4.3.7 Бизнесийн ололт амжилт, зах зээлд шинээр гаргасан бүтээгдэхүүн үйлчилгээний талаар мэдээлэл;
  - 4.3.8 Олон нийтээс хувьцаа хэлбэрээр татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан;
  - 4.3.9 **Сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээлэл:** Санхүүгийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн талаарх мэдээлэл, дээрх хэлцлийг хийснээр гарах үр дүн, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл;
  - 4.3.10 **Цалин урамшууллын мэдээлэл:** Санхүүгийн жилд төлөөлөн удирдах зөвлөлийн хараат болон хараат бус гишүүд, гүйцэтгэх удирдлагад олгосон цалин урамшуулал, шагнал, тэдгээрийн эзэмшдэг опцион болон хувьцааны тоо ширхэг, үнэт цаас гаргагчаас баримталдаг нөхөн олговор, урамшуулал, шагналын талаарх баримталдаг бодлого;
  - 4.3.11 **Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл:** ТУЗ-ийн дарга, хараат, хараат бус гишүүд, гүйцэтгэх удирдлагын мэдээлэл, Удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт, ТУЗ-ийн дэргэдэх хороодын чиг үүрэг, хариуцлага, гишүүдийн нэр, боловсрол, ажлын туршлага, Ёс зүйн кодекс, эрсдэлийн удирдлагын хэрэгжилт, ТУЗ болон түүний дэргэдэх хороодын ажлын тайланг хэлэлцсэн хувьцаа эзэмшигчдийн хурлын дүгнэлт, Гүйцэтгэх удирдлагын ажлын тайланг хэлэлцсэн ТУЗ-ийн дүгнэлт, Дотоод аудитын ажлын тайланг хэлэлцсэн ТУЗ-ийн дүгнэлт, мэдээлэл. Шаардлагатай тохиолдолд Хорооноос баталсан үнэлгээний аргачлалын дагуу өөрийн засаглалыг үнэлсэн үнэлгээний тайлан.
  - 4.3.12 **Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл:** Зах зээлийн эрсдэлийг удирдах чиглэлээр гаргасан үүсмэл санхүүгийн хэрэгсэл болон бусад гуравдагч талтай хийсэн арилжаа, хэлцлийн мэдээлэл, зах зээлийн эрсдэлийг тооцдог арга аргачлал, эрсдэлийг удирдах стратегийн талаарх мэдээлэл;
  - 4.3.13 **Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл:** Тайлант жил дэх эцсийн өмчлөгч болон нөлөө бүхий, хяналтын багц эзэмшигч гадаад дотоодын иргэн, хуулийн этгээдийн нэрс, хувьцааны тоо ширхэг, төвлөрлийн мэдээлэл. Мөн Банкны хувьцаа эзэмшдэг охин, хараат компанийн мэдээлэл, Тайлант хугацаанд Компанийн тухай хуульд заасны дагуу эргүүлэн худалдан авах шаардах эрхээ хэрэгжүүлэн худалдан авсан хувьцааны тоо, үнийн дүнгийн мэдээлэл;
  - 4.3.14 **Ногдол ашгийн мэдээлэл:** Ногдол ашгийн бодлого, тухайн тайлант жилийн хугацаанд хуваарилсан ногдол ашгийн хэмжээ, тараах хэлбэр, ногдол ашиг хуваарилахгүй тохиолдолд энэ талаарх үндэслэл, өмнөх жилд ногдол ашиг хуваарилсан тохиолдолд түүний тараалтын тайлан, мэдээлэл;

- 4.3.15 **Нийгмийн хариуцлага болон үйл ажиллагааны хүрээлэн буй орчны нөлөө:** Тайлант хугацаанд нийгмийн хариуцлага болон хүрээлэн буй орчныг хамгаалах чиглэлээр хийгдсэн ажлын тайлан, мэдээлэл.
- 4.4 Улирлын болон хагас жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг дараа сарын 20-ны дотор олон нийтэд мэдээлэх бөгөөд дараах хэлбэр, агуулгатай байна. Үүнд:
- 4.4.1 Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (цаашид “СТОУС” гэх) болон холбогдох хууль, журмын хүрээнд боловсруулсан хагас жилийн санхүүгийн тайлан, тодруулгын мэдээлэл;
- 4.4.2 Тайлант хугацаанд Банкны үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан;
- 4.4.3 Тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн талаарх мэдээлэл;
- 4.4.4 ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооноос хагас жилийн тайланг хэлэлцэж, тайланд тусгасан мэдээлэл үнэн зөв талаарх дүгнэлт;
- 4.4.5 Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний мэдээлэл;
- 4.4.6 Банк нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл;
- 4.4.7 ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны эзэмшиж буй Банкны хувьцааны талаарх мэдээлэл, Удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт, Дотоод аудитын ажлын тайланг хэлэлцсэн ТУЗ-ийн үнэлгээ, Гүйцэтгэх удирдлагын ажлын тайланг хэлэлцсэн ТУЗ-ийн дүгнэлт, Банкны эцсийн өмчлөгч болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл.
- 4.5 Энэхүү журмын 4.3, 4.4-т заасан мэдээллийн үнэн зөвийг Гүйцэтгэх захирал, Банкны өөрийн болон Хөрөнгийн Биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон Санхүү хариуцсан захирал тус тус хариуцна.

#### ТАВДУГААР ЗҮЙЛ. ТУХАЙ БҮР МЭДЭЭЛЭХ МЭДЭЭ

- 5.1 Банк нь хувьцаа эзэмшигчийн болон хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалтад нөлөө үзүүлэхүйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухай бүр нийтэд мэдээлэх мэдээллийг нөхцөл байдал үүссэнээс хойш ажлын нэг өдөрт багтаан Хороо, Хөрөнгийн Бирж болон өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ. Тухай бүр мэдээлэх мэдээлэлд:
- 5.1.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан;
- 5.1.2 Банкны ТУЗ болон Удирдлагын бүтцэд өөрчлөлт орсон;
- 5.1.3 Нийт ажилтнуудын 15 хувь болон түүнээс дээш хувьд өөрчлөлт орох буюу чөлөөлөгдөх, шилжих, шинээр ажилд орсон талаар мэдээлэл;
- 5.1.4 Банкны болон түүний охин, хараат, зэргэлдээ компанид зохион байгуулалтын өөрчлөлт орсон;
- 5.1.5 Олон улсын санхүүгийн байгууллагаас эх үүсвэр татахаар гэрээ, хэлцэл хийсэн;
- 5.1.6 Банкны хөрөнгийг битүүмжилсэн, эсхүл хураасан;
- 5.1.7 Бусад тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх болсон, Банкны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон;
- 5.1.8 Банкны борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувьд нөлөөлөх үйл ажиллагаатай холбогдох аливаа тусгай зөвшөөрөл, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай байгуулсан гэрээ хэлцлийг цуцлах, дуусгавар болгосон талаар мэдээлэл;

- 5.1.9 Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд, тэдгээрийн компанид эзэмшиж байгаа хувьцаанд өөрчлөлт орсон;
  - 5.1.10 Банкны нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн тухай мэдээлэл;
  - 5.1.11 Эрх бүхий албан тушаалтнуудын хувьцааны эзэмшлийн талаарх мэдээлэл;
  - 5.1.12 Үнэт цаасны зах зээлийн тухайн хуулийн 77 дахь зүйлд заасан дотоод мэдээлэл эзэмшигч, түүнд орсон өөрчлөлт;
  - 5.1.13 Хөндлөнгийн аудиторыг өөрчилсөн талаар;
  - 5.1.14 Санхүүгийн байдлын гадуурх бүртгэлтэй холбоотой санхүүгийн болон санхүүгийн бус эрх үүрэг бий болгосон гэрээ, хэлцэл, гүйлгээтэй холбоотой мэдээллийг мэдээлэх бөгөөд мэдээлэлд гэрээ, хэлцлийн хугацаа, үнийн дүн, төлбөрийн нөхцөл, гүйлгээний товч утга, богино болон урт хугацаат түрээсийн гэрээнээс бий болсон эрх үүрэг, төлбөр түргэн гүйцэтгэх чадвартай холбоотой мэдээлэл;
  - 5.1.15 Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээдээс СТОУС-ын дагуу компанийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэж үзэн дахин үнэлгээ хийхээр шийдвэрлэсэн тохиолдолд холбогдох шийдвэр, шийдвэрийг гаргах болсон нөхцөл, шаардлага, үнэ цэнэ нь буурсан хөрөнгө болон хөрөнгийн үнэ цэнийн бууралтын хэмжээ эсхүл хязгаарын тооцоолол;
  - 5.1.16 Арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн шалгуурыг хангахгүй болсонтой холбогдуулан бүртгэлийн ангилал бууруулах, эсхүл бүртгэлээс хасагдах мэдэгдэл хүлээн авсан тухай мэдээлэл. Хэрэв Банк нь арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд үлдэх хүсэлт гаргасан бол уг хүсэлт хүргүүлсэн огноо болон дээрх мэдэгдлийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ, бүртгэлтэй хугацаанд биелүүлсэн болон хангаж чадаагүй гэрээгээр хүлээсэн үүргийн талаарх мэдээлэл;
  - 5.1.17 Банкны гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн, гарсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд Банкны хувьцааг бирж болон биржийн бус зах зээл дээр худалдах, худалдан авахыг хориглосон арга хэмжээ болон үүнтэй холбогдуулан компанийн ТУЗ-өөс гарсан шийдвэр, арга хэмжээний талаарх мэдээлэл;
  - 5.1.18 Шүүх, прокурор, төрийн эрх бүхий байгууллагаас Банкны эрх бүхий албан тушаалтан, түүний хараат, охин компанийг хариуцагчаар татаж, захиргааны болон эрүүгийн хэрэг үүсгэсэн, шүүхээс дампуурлын тухай хууль тогтоомжийн дагуу эрх хүлээн авагч томилогдсон талаарх мэдээлэл.
  - 5.1.19 Банкны хувьцааны үнэ, ханшид нөлөөлж болох бусад үйл явдал болон хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл.
- 5.2 Банк нь энэхүү журмын 5.1-д заасан мэдээллийг нээлттэй болгохдоо Хороо, Монголбанк болон Хөрөнгийн Биржид тухайн асуудлаар гаргасан албан ёсны шийдвэрийг ажлын Нэг өдөр-т мөн багтаан хүргүүлнэ.
  - 5.3 Энэхүү журмын 5.1-д заасан мэдээллийн үнэн зөвийг Гүйцэтгэх захирал, Банкны өөрийн болон Хөрөнгийн Биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга тус тус хариуцна.

#### **ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. БАНКНЫ ТАЛААР МЭДЭЭЛЭЛ АВАХ**

- 6.1 Банк нь жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр, тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл, тоо, Хороо болон Хөрөнгийн Биржийн дүрэм, журмаар тогтоосон бусад мэдээллийг өөрийн хувьцаа эзэмшигчийн хүсэлтээр түүнд танилцуулна.
- 6.2 Энэхүү журмын 6.1 дэх заалтыг хэрэгжүүлэхдээ Компанийн тухайн хуулийн 98 дугаар зүйлийг мөрдөнө.

## **ДОЛДУГААР ЗҮЙЛ. МЭДЭЭЛЛИЙГ НЭЭЛТТЭЙ БОЛГОХОД ТАВИГДАХ ХЯЗГААРЛАЛТ, ХОРИГЛОХ ЗҮЙЛ**

- 7.1 Дотоод мэдээлэл гэдэгт хувьцааны ханшид нөлөөлөх нийтийн хүртээл болоогүй мэдээллийг дотоод мэдээлэл гэнэ.
- 7.2 Дотоод мэдээлэл эзэмшигч нь тухайн мэдээллийг хууль тогтоомж болон энэхүү журамд заасны дагуу мэдээллийг нээлттэй болгохоос өмнө уг мэдээллийг бусдад дамжуулах, дамжуулах нөхцөл бүрдүүлэхийг хориглоно.
- 7.3 Дотоод мэдээлэл эзэмшигч нь Үнэт цаасны зах зээлийн тухайн хуулийн 78 болон 89 дэх зүйлийн дагуу үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
- 7.4 Нийтэд нээлттэй мэдээлэлд үндэслэн хийсэн дүн шинжилгээ нь хувьцааны ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлөх боломжтой байсан ч түүнийг дотоод мэдээлэл гэж үзэхгүй.
- 7.5 Дотоод мэдээлэл эзэмшигчид нь албан тушаал, ажил үүргийн хувьд мэдээллийг нээлттэй болгох үүрэг хүлээснээс бусад тохиолдолд бусдад дотоод мэдээллийг задруулах.
- 7.6 Банк нь дотоод мэдээллийг Хөрөнгийн Бирж, Хорооноос тогтоосон журмын дагуу нийтэд мэдээлэх ба дотоод мэдээллийг нийтэд мэдээлэхдээ Хороо болон Хөрөнгийн Биржид мэдэгдэнэ.
- 7.7 Дотоод мэдээллийг дор дурдсан хэлбэрээр нийтэд мэдээлнэ:
  - 7.7.1 Банк, Хөрөнгийн Бирж болон Хорооны цахим хуудсаар;
  - 7.7.2 Хорооноос тогтоосон журмын дагуу хэвлэн нийтлэх;
  - 7.7.3 Тухайн мэдээллийг сонирхогч этгээд саадгүй авах боломжийг хангасан бусад хэлбэрээр.
- 7.8 Дотоод мэдээ эзэмшигчийн Банкны хувьцааны арилжаанд оролцох асуудлыг “Дотоод мэдээлэл эзэмшигчийн арилжааны журам”-аар зохицуулна.

## **НАЙМДУГААР ЗҮЙЛ. ХАРИУЦЛАГА**

- 8.1 Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухайн хууль болон бусад холбогдох хууль, журмын дагуу хариуцлага тооцно.